

**ХОТЫН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАГАЖ ЯВАХ ДҮРЭМ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ОЛОН ХОТУУДЫН ХУРАЛ  
БА ТҮҮНИЙ ХЭРГИЙГ ГҮЙЦЭТГЭХ ХОТЫН ЗАХИРГААНЫ  
ГАЗРУУДЫН ДАГАЖ ЯВАХ ДҮРЭМ  
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТИЙН ДҮРЭМ**

**НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.** Монгол Ард Улсын үндсэн хуулийн 30 ба 31 дүгээр зүйлүүдийн ёсоор тус улсын олон хотуудад хотын хурал ба түүний хэргийг гүйцэтгэх хотын захиргааны газрууд байгуулагдмуй.

**ХОЁРДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлыг байгуулахдаа засгийн газраас гаргасан тусгай тогтоолын ёсоор засаг захиргаа буюу худалдаа ба аж үйлдвэрийн явуулга бүхий төв болох бөгөөд нэг мянган хүнээс доош бус хүмүүстэй хотуудад байгуулагдмуй.

**ГУРАВДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлууд нь тус тусын харьяалах хот ба түүний дэвсгэр газруудын дээд эрхийг барих газар мөн болох бөгөөд харьяалах бүхий л олон түмэн зарц ядуу ардыг нэгтгэж, тус улсаас эрхлэн явуулах аливаа хэрэгт оролцуулбаас зохимуй. Хотын хурлуудын чөлөө цагт тус тусын харьяалах хот ба түүний дэвсгэр болох газруудын дээд эрх нь түүний хэргийг гүйцэтгэх хотын захиргааны газраа хадгалагдаж, тогтсон дүрэм заавар дотор дурдсан бөгөөд гүйцэтгэвээс зохих бүхий л үүргийг хотын хурлын өмнөөс гүйцэтгэхээс гадна энэхүү дүрмийн арван гуравдугаар зүйлд дурдсан нь үл хамаармуй.

**ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.** Хотын хурлуудад сонгох ба сонгогдох эрхийг тус улсын үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлгийн ёсоор аливаа хотын дотор буюу түүний дэвсгэр газраа суугаа бүхий л ардууд эдэлмуй.

**ТАВДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурал нь сонголтын тухай гаргасан тусгай дүрмийн ёсоор нэг жилийн хугацаагаар сонгогдмуй. Хугацааны янар хотын хурлын бүх гишүүдийг сонгох явдал нь дээд зохих газрын хурлууд буюу түүний хэргийг гүйцэтгэх газруудаас тушаах аваас үйлдэгдмуй.

**ЗУРГААДУГААР ЗҮЙЛ.** Улаанбаатар хотын хурал нь улсын бага хурлын газраа шууд захирагдах бөгөөд бусад хотуудын хурлууд нь харьяалах аймгуудын их хурал ба аймгийн яамнаа захирагдмуй. Хотын хурлуудын тогтоол ба шийтгэврийг гагцхүү дээр дурдсан тус тусын зохих дээд хурал буюу газруудаас өөрчилж болмуй. Улаанбаатар хотын захиргааны газар нь шууд засгийн газраа захирагдах ба бусад

хотын захиргааны газрууд нь аймгийн яам ба засгийн газраа захирагдах тул эдний тогтоолыг өөрчлөх буюу зогсоох явдлыг тус тусын эрхлэх газраас гүйцэтгэмүй.

**ДОЛООДУГААР ЗҮЙЛ.** Хотын тогтмол хурлыг хоёр сар тутам нэг удаа хуралдах бөгөөд эл хурлыг зарлах ба нээх явдлыг анхдугаар хурлаар сонгогдсон хотын захиргааны газруудаас гүйцэтгэмүй. Хотын онц хурал хуралдуулах явдлыг хотын захиргааны газруудын үзэмжээр буюу хотын хурлын бүх гишүүдийн гуравны нэг хувиас доошгүй гишүүдээс хуралдуулахыг хүсэх аваас зарламуй. Хотын захиргааны газрууд нь өөр өөрийн хөтөлгөн явуулсан ба хийж гүйцэтгэсэн хэрэг ажлын тайланг нэг жилд хоёр удаагаас цөөнгүй хотын хуралд оруулж, хянуулан тогтоолговоос зохимуй. Хотын хурлыг бүх гишүүдийн хагас хувиас доош бус цугларваас хүчин төгөлдөрт тооцож хуралдмуй.

**НАЙМДУГААР ЗҮЙЛ.** Шинэ сонгогдсон хотын хурлын анхдугаар хурлыг хуралдахууд зохих сонголтын комиссын хамтаар хуралдах бөгөөд уг хурлыг орлогч хурлын даргаас нээвээс зохимуй.

**ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ.** Хотын хуралд мөнхүү хурлын гишүүд ба түүний орлогчдыг суулцуулахаас гадна үйлдвэрчний эвлэл, улаан цэрэг, эмэгтэйчүүдийн зэрэг олон нийтийн газруудын төлөөлөгчдийг суулцуулж болох боловч гагцхүү таслах эрхийг хотын хурлын гишүүд эдэлбээс зохимуй.

**АРАВДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлуудад ба хотын захиргааны хурлуудад хэлэлцүүлэх аливаа хэргүүдийг ил бөгөөд олонхын дуугаар шийтгэвээс зохимуй.

**АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.** Хотын захиргааны газрууд нь өөр өөрийн бүхий л ажлыг явуулах тухайд хэзээ ямагт олон ард лугаа гүн холбоотой байхыг хичээж, тэдний хуралд өөрсдийн ба зохих дээд газруудын хөтөлгөн явуулсан хэргийн тухай илтгэл хийх ба хотын захиргааны газруудын өмнө тулгаран ирсэн аливаа асуудлын тухай төлөвлөгөөг тэдний биесээр үйлтгүүлэх буюу хотын хурлын мэргэжин судлах ажилд салбараар уламжлан оруулах зэргээр гүйцэтгэвээс зохимуй.

**АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ.** Хотын захиргааны газрууд нь хуулийн эрх бүхий боловсон хүмүүсийг хэрэглэж болмуй.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **ХОТЫН ХУРЛУУД БА ХОТЫН ЗАХИРГААНЫ ГАЗРУУДЫН ЗОРИЛГЫН ТУХАЙ**

**АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлуудын үндсэн зорилго нь:

1. Дээд газраас гаргасан тогтоол, тушаалыг улмаар биелүүлэн гүйцэтгэх

2. Хот дотор гэгээрэл боловсрол, аж ахуйн ба олон ардын хэв байдлыг улмаар дэвшүүлэн хөгжүүлж, нийгэм журмын байдалд хүргэх гол бодлогыг зохих арга сүвэгчлэн гаргаж гүйцэтгэх тухай хэмжээ авах
3. Нутгийн санхүүг бэхжүүлэн тогтоолгох ба өргөтгөн хөгжүүлэхийн тулд орлогыг түргэтгэн нэмэгдүүлэх арга сүвэгчилж, дээр хоёрт дурдсан хэрэг ажлыг чанартай болгон явуулахыг чухалчлах
4. Тус хотын ач туст нутгийн харьяагаар холбогдох бүхий л асуудлуудыг гүйцэтгэн шийтгэх
5. **Хотон дахь** хувьсгалын ёс журам ба олон нийтийн амгалан байдлыг хамгаалах явдлыг батжуулах

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

#### **ХОТЫН ХУРЛУУДААС БА ХОТЫН ЗАХИРГААНЫ ГАЗРУУДААС**

#### **ГҮЙЦЭТГЭХ ХЭРГИЙН ТУХАЙ**

**АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.** Хотын хурлаас ба хотын захиргааны газруудаас гүйцэтгэвээс зохих зорилгын дотроос ерөнхий явуулгад багтаан явуулбаас зохих зүйлүүд нь:

1. Тогтоосон дүрэм зааврын үндсээр эрхбиш дагаж гүйцэтгэх тогтоол гаргах
2. Хотын хурлын гишүүдийг шинэчлэн сонгох тухайд сонголтын комисс байгуулж, сонголтын хэргийг явуулахын тулд тасгуудыг байгуулах ба олон ажлыг хэрхэн явуулах тухай заавар гаргах
3. Тогтсон хууль дүрмийн ёсоор тусгай тасгуудад сонголт үйлдэх явдлыг өөрчлөх
4. Олон нийтэд зуд гачгийн зэрэг эс мэдэгдсэн аюул тохиолдох аваас түүн лүгээ эсэргүүцэн тэмцэж, устган арилгах ба ядарч зүдээчдэд тусламж олгох тухай хэмжээ авах
5. Гэмт хэрэг өдүүлэгч лүгээ эсэргүүцэн тэмцэж арилгах
6. Үхэх, төрөх, эр эм бололцох зэрэг гэр бүлийн байдлын актыг бүртгэн данслах ба бие хамгаалах бичиг олгосон дотоод, гадаадын хүмүүсийг бүртгэн данслах
7. Улсаас сүм дуганг тусгаарлах явдал үндсэн хуулийн дотор ба төв газруудаас гаргасан хөтөлбөрлөх заавар дотор дурдсанаас ямраар явж буйг хянах

**АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлуудаас ба хотын захиргааны газруудаас санхүү албан татварын явдалд багтаан гүйцэтгэвээс зохих зүйлүүд нь:

1. Хотын санхүүгийн орлого зарлагын төсөвлөсөн дансыг хянан үйлдэж, улмаар зохих газар явуулж батлуулах ба батлуулсан түүнийгээ зохих зүйлд зарцуулах зэргээр гүйцэтгэх

2. Зохих дээд газруудаас тогтоосон ёсоор улсын албан татварыг нэхвэрлэн хурааж, улмаар улсын санд шилжүүлэн оруулах
3. Нийтээр тогтоон зарласан хууль дүрмийн ёсоор харьяат хотын дотор аливаа зүйлд ноогдуулах алба татварыг тогтоож, нэхвэрлэн хураах
4. Шинэ алба татвар гаргах тухай санал бодлогыг зохих газар уламжилж, гүйцэтгүүлэх ба хотын дотор аливаа зүйлд чухал хэрэглэгдэх зүйлийг гүйцэлдүүлэн хангахын тулд улсын алба татварын дээр нэмэгдүүлэн татвар ноогдуулах буюу улсын сангаас буюу албан татвараас зохих хувийг таслуулан авах
5. **Оршломж** /гаргацгүй/ ба зээллэгийн газруудыг байгуулах
6. Тогтоосон дүрэм зааврын ёсоор олон албаны ба хоршоо **күпиритибын** /гаргацгүй/ газрууд лугаа вексель буюу бусад зүйлийн баримтуудаар **оршломжийн** /гаргацгүй/ гэрээ байгуулах эрхтэй баймуй.

**АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлуудаас ба мөн хотын захиргааны газруудаас хотын аж ахуйн явдалд багтаан гүйцэтгэвээс зохих зүйлүүд нь:

1. Өөрсдийн мэдэлд бүхий аж үйлдвэрийн газруудын ажил явуулгын төлөвлөгөө ба төсөвлөсөн данс тайланг шууд баталж, тэдгээрийн ашиг орлогыг хотын санхүүд оруулан авах зэргээр ашиглах
2. Аж үйлдвэрийн ба худалдааны газруудыг шинээр нэмэн байгуулах
3. Тогтоосон дүрэм зааварт нийлүүлэн хотын дотор аж үйлдвэр буюу худалдааны явдлыг хөгжүүлэх тухай хэрэгт тусламж үзүүлэх
4. Аливаа хоршооны газруудад бүхий л хүчээр зохих тусламжийг үзүүлэх
5. Хотын амгалан байдлыг сайжруулах тухай хэмжээ авах
6. Тээх нэвтрүүлэх явдлыг хотын дотор байгуулж түүнийг эрхлэх
7. Гал аюулын хэргийг эрхэлж, түүнийг устган сөнөөх зүйлүүдийг бэлтгэх
8. Олон нийтийн хэрэглэн эдлэх цахилгаан шуудангын хороо, бие угаах ванн, ус бэлтгүүлэх зэрэг газруудыг эрхлэх
9. Хотын доторх аливаа барилгыг сайжруулахаас гадна ялангуяа суух орон байшин барилга зэргийг олшруулан өргөтгөж, гачигдалгүй болгох тухай хэмжээ авах ба тогтоосон дүрэм зааврын ёсоор суух орон савыг эрхлэн захирах
10. Хотын дэвсгэр болох газраас аж үйлдвэрийн явдалд буюу энгийн орон сав барих зэрэгт хэрэглэгдэх газрыг таслан олгох ба газрын хөрсийг боловсруулах аргыг төсөвлөх зэрэг хэргийг гүйцэтгэх
11. Гудамж зээлийг тэгшитгэн засах ба худалдаа үйлдэх газрыг ялган таслах

12. Аливаа зураг төсөвлөгөөг хянан үзэж батлах, албаны буюу аж үйлдвэр хоршоо зэргийн газруудын ба энгийн ардын шинэ бариулах барилгын төсөвлөсөн дансыг хянан үзэж, тогтоон батлах
13. Хотын дэвсгэр дотор бүхий орон барилгуудыг улиран зөөх тухай асуудлыг хянан үзэж, тогтоохууд хотын амгалан байдлыг сахих хамгаалахад буюу улсын төлөвлөгөөний ёсоор хотыг байгуулах барилга үйлдэхэд холбогдол бүхий болох эсэхийг харгалзан хянаж гүйцэтгэх
14. Хотын доторх хашааны газруудын түрээсийн хөлсийг тогтсон дүрэм зааврын ёсоор тогтоож, төлүүлэх явдлыг гүйцэтгэх
15. Хотын дэвсгэр болох газраа бэлчээр, хадлан ба ойн аж ахуйг хөгжүүлэн байгуулах тухай хэмжээ авах
16. Хотын малын ажил ба элдэв зүйлийн тарилга болон бусад газрын аж үйлдвэрийг хөгжүүлэн сайжруулах хэрэгт тусламж үзүүлэх
17. Малын эмнэлэгт тустай зүйлийг байгуулах

**АРВАН ДОЛООДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлуудаас ба мөн хотын захиргааны газруудаас ардыг гэгээрүүлэн боловсруулах явдалд багтаан гүйцэтгэвээс зохих зүйлүүд нь:

1. Харьяат хотын доторх олон түмэн ардыг улс төрийн ба гэгээрэл боловсролын явдалд нэгэн тэгшээр сурган дэвшүүлэхийн тулд мөж уншлагын гэр клуб, улаан булан, бичиг үсэг үл мэдэх явдлыг устгах газар, түр ба жинхэнэ сургууль зэргийг өргөнөөр байгуулах явдлыг чухалчлах
2. Өнчин ядуу хүүхдэд тусламж үзүүлэх ба тэдгээрийг суулгах хэрэгсэл бүхий орон байшин бэлтгэх
3. Судар бичгийн хүрээлэнгийн ажилд туслалцахуй нь хуучны элдэв хөшөө ба уран зохиолын зэрэг зүйлийг хамгаалах ба орон нутгийг судлах ухааны үүрүүдийг байгуулах зэргээр тусламж үзүүлэх
4. Гэгээрэл боловсрол ба шинжлэх ухааныг хөгжүүлэх газруудад зохих тусламжийг үзүүлэх

**АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлаас ба захиргааны газруудаас ардын эрүүлийг хамгаалах явдлын тухай гүйцэтгэвээс зохих зүйлүүд нь:

1. Хотын дотор эмнэлгийн газруудыг байгуулах хэрэгт эдийн тусламж үзүүлэх ба хотын олон ардад эмнэлгийн тусламж үзүүлэх явдлыг зөв замаар явуулахыг хянах

2. Халдвартай ба олон нийтэд дэлгэрсэн элдэв өвчнийг анагааж, устгах явдалд зохих тусламж үзүүлэхээс гадна эл өвчнийг улмаар олон нийтэд дэлгэрүүлэхгүйг чухалчлах
3. Эрүүлийг хамгаалах салбар ба эмнэлгийн бүхий л газруудад тусламж үзүүлэх
4. Амралтын цэцэрлэгийн газар ба харгалзагчийг байгуулж, хотын дотор эрүүл мэнд байлгах тухай чухал хэмжээ авах ба элдэв өвчин ба зүйлийг устгахын тулд ариун цэвэр байдалд оруулах явдлыг чухалчлах
5. Олон ардын биеийн тамирыг сайжруулах явдлыг хөгжүүлэх тухай хэмжээ авах
6. Эх ба нялхсыг хамгаалах газруудыг байгуулах явдлыг эрхлэхээс гадна хүүхдийн цэцэрлэг, саатаа зэргийг байгуулбаас зохимуй.

**АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ.** Хотын хурлаас ба мөн хотын захиргааны газруудаас үгээгүү ядуусыг тэтгэн тэнхрүүлэх явдлыг тогтсон дүрэм зааврыг баримтлан дагаж гүйцэтгэмүй.

**ХОРЬДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлаас ба мөн захиргааны газруудаас шүүх таслах газрыг байгуулах тухай гүйцэтгэвээс зохих зүйлүүд нь:

1. Шүүх таслах газрын гишүүн ба байцаагч нарт хэн хэнийг сонговоос зохих нэрийг нэгэн хамт суугаа хот буюу сумаас цохож, аймгийн хурлаар сонгуулахын тулд уг нэрсийг хүргүүлэх бөгөөд Улаанбаатар хотын хурал ба захиргааны газар нь шүүх таслахын гишүүдийг шууд сонгож, Шүүх Явдлын Яаманд хүргүүлж батлуулмуй.
2. Улаанбаатар хотоос бусад хотуудын шүүх таслах газрын гишүүдийг сайшаан магтах буюу муушаах явдлыг харьяат аймгийн яамнаа оруулах бөгөөд Улаанбаатар хотын шүүх таслах газрын гишүүдийг сайшаах буюу муушаах явдлыг тус хотын хурлаас гүйцэтгэмүй. Эл бүхий л сайшаах буюу муушаах явдал нь Шүүх Яамаар батлагдмуй.
3. Улаанбаатараас бусад хотуудын шүүх таслах газрын байцаагч нарыг батлах ба сайшаах буюу муушаах явдлыг харьяат аймгийн яам лугаа зөвлөж, аймгийн хууль сахигчид оруулах зэргээр гүйцэтгэх бөгөөд Улаанбаатар хотноо аваас байгуулах ба сайшаах буюу муушаах явдлыг тус хотын хууль сахигчийн дурдсанаар шууд гүйцэтгэмүй.
4. Ардын төлөөлөгчдийг сонгох ба тэднийг муушаах ба сайшаах явдлыг гүйцэтгэх
5. Шүүх таслах газрын ба байцаагч нарын хийж явуулсан хэргийн илтгэлийг сонсож гүйцэтгэх

6. Олон ардад хууль цаазын тусламж үзүүлэх газруудыг байгуулах
7. Шүүх таслах газрын аливаа салбаруудаас өөрт ноогдсон үүрэг зорилгыг гүйцэтгэх тухайд зохих тусламжийг үзүүлэх
8. Орон нутгуудад гянднаа хоригдсоны эрхлэн хянах буюу тэдний хийж буй ажилд тусламж үзүүлэх ба албадан ажил хийлгэх явдлыг удирдахаас гадна аливаа газруудаас чөлөөгөөр хасагдагчдын чөлөөлөгдөх тухайд тусламж үзүүлэх явдлыг гүйцэтгэх

Үүнд тайлбарлах нь: Улаанбаатар хотод аваас аливаа газруудад ардын чөлөөг хасах ба албадан ажил хийлгэх явдлыг удирдан хэлж гүйцэтгэхийг шууд Шүүх Явдлын Яамнаас эрхлэн гүйцэтгэгдмүй.

**ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.** Хотын хурлууд ба мөн захиргааны газруудаас цэргийн тухай гүйцэтгэвээс зохих зүйлүүд нь:

1. Олон ардыг эрхбиш цэргийн албанаа оруулах хэргийг цэргийн аливаа салбаруудаас гүйцэтгэх тухайд зохих тусламж үзүүлэх
2. Нас тэнцэж буюу дайчлагдаж татагдах ба цэргийн татвар хураах тухайд туслалцан гүйцэтгэлцэх
3. Цэргийн настныг бүртгэх ба цэргийн ачаа тээх буюу тээх нэвтрүүлэх хөрөнгө зүйлийг бүртгэх буюу бэлтгэх явдлыг гүйцэтгэлцэх
4. Цэргийн албанаас оргож зайлах явдлыг эсэргүүцэн устгах хэрэгт туслалцах
5. Цэргийн газруудаас хууль дүрмийн ёсоор даалгасан хэргүүдийг гүйцэтгэх

**ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлаас ба мөн захиргааны газруудаас үндэс угсааны хэрэгт харьяалах хотын дэвсгэрт оршин суугаа аливаа яс угсааны олон ардад гэгээрэл боловсролын ба тэтгэн тэнхрүүлэх явдалд хэрэглэгдэх зүйлүүдийг хангах тухай хэмжээ авах

**ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлуудаас жинхэнэ гүйцэтгэвээс зохих зүйлүүд нь:

1. Зохих дээд хурлуудад одуулах төлөөлөгчдийг сонгох
2. Хотын хурлаас явуулах ажлын төлөвлөгөөг батлах
3. Хотын захиргааны газруудын хийж явуулсан хэргийн тайланг хянан үзэж, батлах
4. Олон нийтийг улс төрийн ба гэгээрэл боловсрол, аж ахуйн хоршооны зэрэг улсаас явуулж байгаа хэрэг ажилд танилцуулахын тулд харьяалах хотноо бүхий албан яамны буюу аж үйлдвэрийн олон газруудын илтгэлийг сонсгох

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **ХОТЫН ЗАХИРГААНЫ ГАЗРУУДЫН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ**



**ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.** Хотын хурлууд нь харьяат хотын аж ахуйг эрхлүүлэн гүйцэтгүүлэх ба бүхий л ажлыг удирдан явуулахын тулд өөрсдийн гишүүдийн дотроос хотын захиргаа ба түүний даргыг сонгомуй. Улаанбаатар хотноо аваас хотын захиргааны газрыг долоон хүмүүсийг гурван орлогчтойгоор сонгож, байгуулмуй. Эдгээрийн дотроос дарга ба даргын орлогч хоёр хүмүүс цалинтай баймуй. Нөгөө бусад хотууд нь хотын захиргааны газрыг гурван хүмүүсийг хоёр орлогчтойгоор сонгож байгуулмуй. Эдгээрийн дотроос гагцхүү дарга нь цалинтай баймуй.

**ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛ.** Улаанбаатар хотын захиргааны газраа өдөр тутмын ажлыг гүйцэтгүүлэхийн тулд байгуулагдах хэлтсүүдийг тодорхойлбоос: Ерөнхий, Аж ахуй, Санхүүгийн, Ардыг гэгээрүүлэх, Цэргийн, Хянан байцаах, Хүчнийг хамгаалах эдгээр бөгөөд жич хотын цагдан сэргийлэх газар хотын ариун цэврийг сахих доктор байгуулагдмуй. Бусад хотуудын захиргааны газар Ерөнхий, Аж ахуйн хоёр хэлтэс байгуулагдах бөгөөд хэрвээ хотын захиргааны газруудаас өөр хэлтэс нээхийг хүсэж, мэдүүлэх аваас улсын Хянан Байцаах Яамнаас Сангийн Яам лугаа зөвлөж, хянуулан баталж болмуй.

Гадна Улаанбаатар хотноо шүүх таслах газруудыг байгуулах дүрмийн ёсоор ардыг шүүх таслах газар ба хууль сахигчийг байгуулмуй.

Тайлбарлах нь: Хотын захиргааны газруудын хэлтсүүдийн дагаж явах дүрмийг энэхүү дүрмийн ёсоор харьяат хотын захиргааны газруудаас төлөвлөн зохиож, улмаар зохих газраа явуулж батлуулмуй.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **ХОТЫН ХУРЛУУДЫН САЛБАРЫН ТУХАЙ**

**ХОРИН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлын бүх гишүүдийг хотын захиргааны ба хотын аж ахуйн аливаа хэрэг ажилд гар бие оролцон туслалцахын тулд ба мөн энэхүү ажилд нийт олон ардыг танилцуулан оролцуулах хэргийг гүйцэтгүүлэхийн тулд хотын хурлуудын дэргэд салбаруудыг байгуулмуй. Энэхүү салбарууд нь хотын хурлын ба захиргааны газруудын тогтоол тушаалыг гүйцэтгэх явдалд тусламж үзүүлэх, хотын захиргааны газруудын хэлтсүүдийн ба бусад хотын хурлын мэдэлд бүхий газруудын явуулсан хэрэг ажлыг шалгах ба хянах үүргийг хүлээмүй.

**ХОРИН ДОЛДУГААР ЗҮЙЛ.** Салбарын тоо ба түүний тус бүрийн үүргийг ялгаварлан тогтоох явдлыг хотын хурлаас буюу хотын захиргааны газруудаас гүйцэтгэмүй.

**ХОРИН НАЙМДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлуудын дэргэд байгуулагддаас зохих салбаруудыг нэрлэвээс хотын Аж ахуйн, Санхүүгийн, Ардыг Гэгээрүүлэх, Эрүүлийг



Хамгаалах, Хоршоо Худалдааны Захирах Тушаахын Суурийн, Улсын Хянан Байцаахад тусламж үзүүлэх зэрэг эдгээр болмуй.

**ХОРИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ.** Хотын хурлын бүх гишүүд нь аль нэгэн салбарт өөр өөрийн дураар орох боловч хотын хурлын гишүүд тус бүр аль нэгэн салбарт ажил хийх үүрэг бүхий байваас зохимуй.

**ГУЧДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлын гишүүд ба түүний орлогчдоос өөр энэхүү салбаруудад оролцуулбаас зохих нь: Үйлдвэрчний эвлэл, Улаан цэрэг, Эмэгтэйчүүдийн зэрэг олон нийтийн газруудын төлөөлөгчид буюу ямар нэгэн салбарт ажил хийхийг дурлах, чадвар бүхий этгээдийг оруулж байваас зохимуй.

Жич. Энэхүү салбарын орон тоонд эрхбиш хотын доторх ямарваа нэгэн зүйлийн ажилд зохисоор удирдах этгээдийг оролцуулваас зохимуй.

**ГУЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.** Эл салбарын хэрэг ажлыг явуулахад түүний бүх гишүүд нь цөм таслах эрхийг эдлэх ба олон нийтийн албан ажил үлэмжидсэнээр аваачиж уг албыг гишүүд нь ямарваа хөлс цалингүйгээр гүйцэтгэвээс зохимуй.

**ГУЧИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ.** Салбарууд нь өөрсдийн дундаас мөн өөрсдөд олгосон эрхийн хугацааны ёсоор тусгай товчоо сонгомуй. Энэхүү товчоонд хот доторх ямарваа нэгэн зүйлийн ажлыг удирдах этгээдийг эрхбиш оролцуулмуй.

Жич. Товчоо нь өөрсдийн дундаас дарга, даргын орлогч ба нарийн бичгийн дарга нарыг тус тус сонгомуй.

**ГУЧИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ.** Салбарын товчоонууд нь өөр өөрийн салбарын бүгд хуралд оруулж хэлэлцүүлэх хэргийг төлөвлөгөөг бэлтгэх, салбарын гишүүдийг ба мөн хуралд ирсэн гишүүдийг тус тус бүртгэх, салбараас хийж явуулсан хэргийн тайлан илтгэлийг зохиох, салбарын хурлын тогтоолыг зохих газар явуулах, мөнхүү тогтоолыг улмаар гүйцэтгүүлэх явдлыг хянан хичээх, хотын захиргааны газруудын хуралд өөрсдийн төлөөлөгчийг зөвлөх эрхтэйгээр суулцуулах

**ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.** Салбаруудын тус бүрийн эрх үүргийг тодорхойлбоос:

**Нэг.** Ямар нэгэн зүйлийн аж ахуй буюу түүний эрхлэх газрын явуулбаас зохих ажлын төлөвлөгөөг хянан үзэж тогтоох

**Хоёр.** Зохих газруудын тайлан илтгэлийг сонсож, түүний тухай өөрсдийн саналыг хотын хуралд буюу хотын захиргааны газар оруулах

**Гурав.** Хотын захиргааны газруудын өдөр тутмын явуулах хэргийн үндсэн асуудлуудыг хянан үзэж, өөрсдийн саналыг өгөх

**Дөрөв.** Олон албаны ба аж үйлдвэрийн газруудын тус тусын эрхлэн явуулах ажил хэргүүд лүгээ танилцах

**Тав.** Тус салбарын гишүүдээс тусгай өөрсдийн явуулан буй хэрэг ажлын тухай оруулан ирсэн дүрэм төлөвлөгөө зэрэг зүйлүүдийг хянан хэлэлцэх

**Зургаа.** Ямар нэгэн албаны буюу аж үйлдвэрийн газруудаас өөр өөрийн эрхлэн явуулбаас зохих хэрэг ажлын тухай үйлдсэн дүрэм ба төлөвлөгөөг хянан үзэж, тогтоох

**Долоо.** Тус салбараас гаргасан тогтоол ба төлөвлөгөө зэргийг гүйцэтгэсэн тухай товчооны илтгэлийг сонсгох

Үүнд тайлбарлах нь: Эл дурдсан үүргийг салбаруудаас гүйцэтгэхэд гагцхүү хотод хамаарах албан газруудын тухай гүйцэтгэгдмүй.

**ГУЧИН ТАВДУГААР ЗҮЙЛ.** Салбаруудын тогтоолыг батлах ба улмаар биелүүлэн явуулах явдлыг хотын захиргааны газраар уламжлан гүйцэтгэгдмүй. Хэрвээ салбараас хотын захиргааны газраас тогтоосныг зөвшөөрөхгүй зүйл гарах аваас салбар нь уг хэргийг хотын хуралд оруулж хэлэлцүүлэх эрхтэй баймуй.

**ГУЧИН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ.** Бага зэргийн төлөвлөгөө, сэдэв хэрэглэгдэх асуудлуудыг хотын захиргааны газруудаас зохих салбаруудад өгч уг зүйлийг гүйцэтгүүлмүй.

**ГУЧИН ДОЛООДУГААР ЗҮЙЛ.** Салбаруудаас явуулах хэрэг ажлын ерөнхий удирдлага нь хотын хурал ба түүний хэргийг гүйцэтгэх хотын захиргааны газруудад баймуй.

**ГУЧИН НАЙМДУГААР ЗҮЙЛ.** Салбаруудын хурлыг хотын захиргааны газруудаас тогтсон хугацаануудад хуралдваас зохимуй.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ**

### **ХОТЫН ХУРЛЫН ГИШҮҮДИЙН ЭРХ БА ҮҮРГИЙН ТУХАЙ**

**ГУЧИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ.** Хотын хурлын гишүүд нь хотын ба салбарын бүхий л хурлуудад суулцах үүрэгтэй бөгөөд тэдний даалгасан зүйлүүдийг нэгд нэгнээр тус тус гүйцэтгэмүй.

### **ХОТЫН ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ӨӨР ӨӨРИЙН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХҮЙ НЬ:**

Нэг. Хотын хурлын буюу аль түүний нэг салбарын хурлын ажилд биеэр оролцон туслалцах

Хоёр. Өөрсдийн албаны буюу аж үйлдвэрийн газруудын ба бусад тэр мэт олон нийтийн газруудын хэрэг ажилд оролцон туслалцах

Гурав. Нийт олон ардтай шууд хэлхээ холбоог өргөнөөр зузаатгах

### **ХОТЫН ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ҮҮНИЙГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХИЙН ТУЛД:**

Нэг. Аж ахуйн буюу түүний эрхлэх явдлын талаар тэдний зохих ажил лугаа биеэр танилцах

**Хоёр.** Аливаа албаны буюу аж үйлдвэрийн газруудын ажил явуулгыг сайжруулахад илт мэдэгдсэн дутагдалтай зүйлийн тухай өөрсдийн санал онолыг гаргаж, зохих газар мэдүүлэх

**Гурав.** Хотын хурлаас ба өөрсдийн салбараас буюу өөрийн хийж явуулсан хэрэг ажлын тухай тайланг олон нийт ардуудад тайлбарлан илтгэж, танилцуулах ба олон ардаас гаргасан санал шүүмжлэлийг өөрийн салбарын буюу хотын их хурлуудад оруулж, хэлэлцүүлэн тогтоолгох

**Дөрөв.** Хотын хурлаас ба хотын захиргааны газруудаас гаргасан тогтоол зааврын ёсоор явуулж буй эсэхийг хянахаас гадна мөнхүү тогтоол зааврыг гүйцэтгэх тухайд тулгарлан мэдэхгүй зүйл гарах ахул цаашид мэдүүлбээс зохимуй. **ДӨЧДҮГЭЭР ЗҮЙЛ.** Олон нийтийн идэвх оролдлогыг өргөтгөхийн тулд хотын хурлын гишүүдээс гүйцэтгэвээс зохих зүйлүүд нь:

**Нэг.** Хотын хурлаас буюу түүний салбаруудаас тогтоовоос зохих аливаа асуудлуудыг олон нийтийн хуралд оруулж, хэлэлцүүлэх

**Хоёр.** Хотын хурлын тогтоолуудыг олон ардад тайлбарлан сонсгохоос гадна түүний хэрхэн гүйцэтгэх тухай ёсыг тайлбарлан таниулах

**Гурав.** Аливаа гомдол мэдүүлэг зэргийг хүлээн авч улмаар зохих газар явуулж тогтоолгох

**ДӨЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.** Хотын хурлын гишүүд нь өөрсдийн үнэмлэх бичгийг үзүүлмэгц ямарваа албан буюу аж үйлдвэрийн газруудад буюу тэдгээрийн албаны хүмүүс лүгээ чөлөөтэй бөгөөд ээлж хүлээх явдалгүй уулзаж болох ба мөн тэдгээрээс зохих зүйлд хэрэглэгдэх баримт хуудсыг авах эрхтэй байхаас гадна нууц хэргийн зүйлээс бусад хэргүүдийг мөн тайлбарлан таниулж болмуй.

**ДӨЧИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлын гишүүд нь хотын захиргааны газраас буюу түүний даргаас тэдний барих буюу хорих тухай сэдэв баримт гаргасангүй аваас тэдний биесийг барих буюу хорьж үл болмуй.

**ДӨЧИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ.** Хотын хурлын гишүүд нь уг орон тооноос хасагдах учир шалтгааныг дурдваас:

**Нэг.** Суух газрыг улирах аваас

**Хоёр.** Сонголтын эрхийг хасагдваас

**Гурав.** Өөрт ноогдсон үүргийг санаатайгаар үл гүйцэтгэснийг олон ардаас шүүмжлэн илрүүлэх аваас буюу ямарваа шалтгаангүйгээр хотын ба салбарын болон комиссын хурлуудыг удаа дараа тасалдуулах ба мөн хотын хурлаас ба хотын захиргааны газраас буюу салбарын товчоодоос даалгасан зүйлүүдийг гүйцэтгэхийг үл зөвшөөрөх аваас

**Дөрөв.** Үл зохилдох буюу гэмт явдал гаргах аваас хотын хурлын гаргагдсан гишүүдийн орныг тэдний орлогчоос зохих тогтмол цэс дансны ёсоор оруулж гүйцэтгүүлмүй.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ**

### **ХОТЫН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ИТГЭМЖЛЭХ БИЧГҮҮДИЙГ ШАЛГАХ КОМИССЫН ТУХАЙ**

**ДӨЧИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.** Итгэмжлэх бичгүүдийг шалгах комиссуудыг хотын хуралд шинэ сонгогдсон тэргүүлэгчдийн анхдугаар хурлаар гишүүн гурвыг орлогч хоёрын хамтаар хотын хурал хэчнээн хугацаагаар сонгогдсон түүний нэгэн адил хугацаагаар сонговоос зохимой.

**ДӨЧИН ТАВДУГААР ЗҮЙЛ.** Итгэмжлэх бичгүүдийг шалгах комиссын зорилгыг дурдваас:

**Нэг.** Хотын хурлын бүх гишүүдийг орлогчдын хамтаар тэдний сонголтын тасгуудаар ялгаварлан маягийн ёсоор бүртгэн данслахаас гадна хотын хурлын гишүүдэд оролцоогүй салбарын гишүүдийг бүртгэх

**Хоёр.** Хотын хурлын гишүүдийг зөвөөр сонгосон эссэнийг шалган үзсэн тухай шинэ сонгогдсон хотын хурлын тухай анхдугаар хуралд илтгэлийг оруулж батлуулах